



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2012 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн
бүрэлдэхүүн батлах тухай

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлд Засгийн газрын байгууллага, Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагаас орох төлөөллийг дор дурдсанаар баталсугай:

- | | |
|--------------|---|
| Дарга | -Монгол Улсын Ерөнхий сайд |
| Орлогч дарга | -Эрдэс баялаг, эрчим хүчний сайд |
| Гишүүд: | -Сангийн сайд; |
| | -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд; |
| | -Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); |
| | -Монгол Улсын Ерөнхий аудитор (зөвшилцсөнөөр); |
| | -Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр); |
| | -Авлигатай тэмцэх газрын дарга (зөвшилцсөнөөр); |
| | -Төв аймгийн Засаг дарга. |
| | Нарийн бичгийн дарга |

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэгт Засгийн газрын байгууллага, Улсын Их Хурлын харьяа байгууллагаас орох төлөөллийг дор дурдсанаар баталсугай:

- | | |
|---------|--|
| Ахлагч | -Ерөнхий сайдын ахлах зөвлөх |
| Гишүүд: | -Татварын ерөнхий газрын дарга; |
| | -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга; |
| | -Ашигт малтмалын газрын дарга; |
| | -Газрын тосны газрын дарга; |

- Засгийн газрын ахлах референт;
- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр);
- Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга;
- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга;
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч.

Нарийн бичгийн дарга -Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын албаны зохицуулагч.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт орох компани, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг ажлын 10 хоногт багтаан томилж, гаргасан шийдвэрээ Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргад ирүүлэхийг Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, иргэний нийгмийн "ТАН" эвсэл, Байгаль орчны иргэний нийгмийн зөвлөлд зөвлөсүгэй.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Ерөнхий сайдын 2009 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД